

**ЗАРИМ ТӨРЛИЙН ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮР
ЗОГСООХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “төрийн бусад байгууллагаас” гэсний дараа “хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учруулж болзошгүй хор хохирол, үр дагаврыг харгалзан их эрсдэлтэйгээс бусад объектод” гэж нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд,
А.Адъяасүрэн, Ж.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа,
Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр, Ц.Цэрэнпунцаг
/Цаашид “Ажлын хэсэг” гэх/**

2.Төслийн 3 дугаар зүйлийн “2 дугаар зүйлд” гэсний өмнө “1,” гэж, “хяналт шалгалтыг хийхдээ” гэсний өмнө “төрийн” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

3.Төслийн 3 дугаар зүйлийн “зөрчилд” гэснийг “зөрчил дутагдалд” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

4.Төслийн 4 дүгээр зүйлийн “Санхүүгийн зохицуулах хороо” гэсний дараа “Хадгаламжийн даатгалын корпорац,” гэж нэмэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Энэ хууль батлагдсантай холбогдуулан иргэн, хуулийн этгээд дотоод хяналт шалгалтаа зохион байгуулж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллаж, холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Тайлбар: Энэ санал дэмжигдсэн тохиолдолд төслийн зүйлийн дугаарыг өөрчлөх.

6.Төслийн 7 дугаар зүйлийн “Энэ хуулийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний” гэснийг “Энэ хуулийг хүчин төгөлдөр болсон” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг